

Түвшинширээ сумын 2021 оны 06 дугаар сарын ажлын товч мэдээ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар болон аймгийн Засаг даргын захирамжууд, аймгийн Онцгой байдлын газраас өгсөн цаг үеийн холбогдолтой үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Багийн Засаг дарга нар харьяа багийн малчин өрхүүдээр 05 сарын 25-30-ны хооронд тойролтоор явж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хийгдэх ажлын саналыг авч, малын тоо толгойн албан татвар, нийгмийн даатгал болон бусад хууль тогтоомж, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сануулга гарын авлага, ноос ноолуурын урамшууллын талаар мэдээлэл өглөө.

Сумын Засаг даргын 2021.06.14-ны өдрийн А/65 тоот захирамжаар хагас жилийн мал тооллогын ажлын хэсэг байгуулагдаж хагас жилийн мал тооллогыг 6 сарын 15-ны өдрөөс 6 сарын 22-ны хооронд зохион байгууллаа. Сэргэлэн багийн 18 өрх, Өлзийт багийн 32 өрх, Үнэгд багийн 29 өрх, Дэлгэрхаан багийн 19 өрх, Өгөөмөр багийн 39 өрх нийт 137 өрхийн малыг багийн засаг дарга нар тоологчийн хамт сонгогдон ирсэн айл өрхөөр явж тоолсон. Сэргэлэн баг 182км, Өлзийт баг 341км, Үнэгд баг 435км, Дэлгэрхаан баг 364км, Өгөөмөр баг 328км тус тус явсан байна. Сумын хэмжээнд: Тэмээ – 519, Адуу – 3979, Үхэр – 4562, Хонь – 46987, Ямаа – 31531 толгой мал тус тус тоологдсон байна.

2021.06.17-нд сумын Засаг даргын А/67 “Ковид-19 цар тахлын сэжигтэй тохиолдол батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” захирамж гарч иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тэг зогсолтыг тодорхойгүй хугацаагаар тогтоолоо. Коронавируст халдварын тандалт судалгааг эрчимжүүлж, батлагдсан иргэний ойрын болон дам хавьтлыг тогтоох ажлыг шуурхай зохион байгуулж ажиллалаа.

Батлагдсан тохиолдлын ойрын болон дам хавьтагч нарыг шуурхай илрүүлж, ойрын хавьтагч 14 иргэний ПСР шинжилгээний хариу сөрөг гарсан учраас 2021.06.22-нд “Тэг зогсолт цуцлах тухай” А/68 дугаар захирамжаар тэг зогсолтыг цуцалж худалдаа үйлчилгээний газрууд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллаж эхэлсэн. Ажлын хэсэг хяналтыг тогтмол хийж байна.

Байгууллагуудад албан даалгавар болон захирамжуудыг хүргүүлэн, байгууллага бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна. 01 дүгээр албан даалгаврын биелэлтийг 7 хоног бүр аймгийн Шуурхай штабт хүргүүлэн ажиллаж байна.

Сумын орох гарах хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор 4 гэр постыг сумаас орох гарах замуудад гарган ажиллаж байна. Хөдөлгөөнт постуудад төрийн байгууллагын

албан хаагчид жижүүрлэн ажиллаж байна. Хөл хорио тогтоосонтой холбогдуулан хөдөлгөөнт болон хяналтын постуудын бензин шатахууны зардалд одоогоор 6,2 сая төгрөгийн зардал гараад байна.

Сумын шуурхай штаб нь 24 цагаар жижүүрлэн ажиллаж байна.

2021 оны 06 дугаар сарын байдлаар сумын нийт хүн ам 3421, сумын нийт өрх 976, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн хүүхэд 6 дугаар сарын байдлаар 21, нас барсан 8 хүн бүртгэгдсэн байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ундны усны худаг гаргах-30 сая, сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх-100,0 сая, сумын төвийн гэрэлтүүлэг -35,0 сая, сумын төвийн камержуулалт-23,0 сая төгрөгийн ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах тендерүүдийг тус тус зарлан тендер нээх, хянан үзэх, үнэлэх ажлыг үнэлгээний хороодоор зохион байгуулж байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 10,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ундны усны худгийн засварын ажлыг журмын дагуу шууд худалдан авах гэрээгээр хийж гүйцэтгэж байна. Үүнд худгийн барилгыг дулаалж доторлох, хуучин 3 тонны зэвэрсэн усан санг сольж стандартын шаардлага хангасан нержин 5тонны өвлийн дулаалгатай танктай болгох, карт уншдаг ухаалаг төхөөрөмж тавьж ухаалаг худаг болгох ажлууд хийгдэж байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 20,0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын хүрээнд хуучин цэцэрлэгт хүрээлэнгийн шаардлага хангахгүй хашаа хайсыг авч шинэ хашаа хайс татаж, 200 ширхэг мод бут нөхөн тарилаа.

Улсын Их хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нарын санаачлалаар тус сумын 2-р багийн нутаг “Цагаан өндөр”-т хээрийн сайт байгуулахаар товлогдон, үүрэн холбооны Юнител компанийн инженерүүд газар дээр нь ирж хэмжилт хийн 7 сард байгуулахаар төлөвлөлөө.

Сумын залуучууд өөрсдийн дотоод нөөц бололцоогоор тоглоомын талбайн гадаах сагсан бөмбөгийн талбайг хатуу хучилттай болгож залуучуудын дунд 3х3 сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.

Сумын Соёлын төвд 14.7 сая төгрөгийн үнэ бүхий үзэгчдийн сандал, номын сангийн уншлагын танхимын ширээ сандал, номын тавиурууд, оффис ширээнүүд, бичиг хэргийн шүүгээ зэрэг хөрөнгө оруулалтыг Соёлын яамнаас шийдвэрлэлээ.

ЕБС-ын нэг ангийн иж бүрэн багш, сурагч ширээ, сандал, самбар, бичиг хэргийн шүүгээ зэрэг нийт 3,9 сая төгрөгийн үнэ бүхий зүйлийн хөрөнгө оруулалтыг УИХ-ын гишүүн Ж.Батсуурь шийдвэрлэж өглөө.

Сумын татварын орлогын гүйцэтгэл дараах байдалтай байна.

Улсад төвлөрүүлэх төвлөрсөн төсвийн орлогод 2300,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2833,0 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 123,2 хувиар буюу 533,0 мянган төгрөгөөр

Аймагт төвлөрүүлэх татварын орлогод 47885,2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 51562,9 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 107,7 хувиар буюу 3677,7 мянган төгрөгөөр

Сум орон нутгийн татварын орлогод 10642,4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 51626,6 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 485,1 хувиар буюу 40984,2 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлж ажиллаад байна.

Ноолуурын урамшуулал авсан иргэний ХХОАТатварын тайланг хялбаршуулсан горимоор тайлагнаж тайланг илгээж байна.

Ногоон байгууламжийн усалгааг 7 хоногт 2-3 удаа усалгааг хийж, ундны ус зөөврийн машины торх, ёмкосыг 7 хоногт 2 удаа содтой усаар цэвэрлэж ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж байна. Үнэгд багийн нутаг Цагаан-Өндөр, Уурхайтын айраг гэх газарт уул уурхайн ашиглалтын зөвшөөрөлтэй “Жи Би Эм” ХХК хайгуулын ажил хийхээр 11 хүний бүрэлдэхүүн 2 техниктэй ирж, байгаль хамгаалах төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж, хайгуулын ажил хийгдэж байна. Хайгуулын ажлын явц үйл ажиллагаанд Үнэгд багийн ИНХ-ын дарга Банзрагч, ИБХ Н.Дэмбэрэлдодов, ИБХ Н.Жаргалсайхан нар хяналт тавин ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн судалгааны ажлын хэсэг 2021 оны 06 сарын 18 нд ирж Донгойн ширээ, Цагаан элэгтийн хадны бичээс, Бичигт хад газруудаар явж зураг авалт хийж орчны нөхцөл байдал, дурсгалуудын талаарх судалгааг хийсэн.

Хүнсний 14 хүнсний дэлгүүрээс долоо хоног бүрийн Даваа, Пүрэв гарагуудад өргөн хэрэглээний хүнсний нөөцийн мэдээг авч нэгтгэн аймгийн ХХААЖДҮГ –т хүргүүлж байна.

Сумын хүнсний худалдаа үйлчилгээ үзүүлж буй 14 дэлгүүр, 5 хоолны үйлчилгээ үзүүлж буй иргэний цайны газарт мэргэжлийн хяналтын газраас ирсэн заавар

зөвлөмжийн дагуу “Ковид-19” өвчний үед ажиллаж буй байдалтай танилцаж дүгнэлт, заавар зөвлөгөө өгч, гаргасан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн судалгааг хагас жилийн байдлаар гаргасан. Сум хөгжүүлэх сангийн зөвлөлийг шинээр батлуулах хүсэлтийг сумын ИТХ-д санал оруулаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд гаргах 2 худгийн 1 худгийн цооног гаргасан, сумын ОНХС-гийн хөрөнгөөр гаргах 1 худгийн цооног өрөмдсөн байдалтай байна.

2021 оны 6 дугаар сарын 3-нд Дэлгэрхаан багийн малчин Д. Эрдэнэболдынхоос дуудлага ирсний дагуу тус багийн малын эмч Н. Минжбадгар очиж малд үзлэг хийж дээж авч аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлж, цусан халдварт болох нь батлагдсан. Үүний дагуу тухайн бүс нутгийн айл өрхийн мал сүрэгт цусан халдвартын вакцин хийсэн.

2021.06.08-ны өдөр Түвшинширээ сумын Өгөөмөр багийн Таван толгой гэдэг газраас гоц халдварт шүлхий /A0-10/ өвчний сэжиг бүхий дуудлага ирж, “Түвшинтаван-Эрдэнэ” ХХК-ын малын их эмч Н. Давааням дуудлагын дагуу очиж бүх малд үзлэг хийж, шинж тэмдэгтэй 8 малыг ялгаж, тусгаарлан, сумын мал эмнэлгийн тасагт мэдэгдсэн.

Үүний дагуу Аймгийн мал эмнэлгийн газарт мэдэгдэж, Аймгийн мал эмнэлэг ариун цэврийн лабораториос 2 эмч ирж дээж авч түргэвчилсэн тестээр хариу зэрэг гарч, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид дээжийг хүргүүлсэн.

Сумын Засаг даргын 2021.06.09-ны өдрийн А/60 захирамжаар Өгөөмөр багийн Тавантолгой гэх газар хязгаарлалтын дэглэм тогтоож, сэжигтэй бүсэд анхааруулга сэрэмжлүүлэг өгч, ариутгал халдваргүйжүүлэлт хийх багаж хэрэгсэл, анхааруулга, таних тэмдгийг байршуулж ажилласан.

Одоогийн байдлаар голомтын бүсийн өрхөд нийтдээ 15 хашаа 18000 м/кв хашаа хороо, 10 ш худаг 2500 м/кв талбай, автомашин 15 ш тус тус ариутгасан байна.

Мөн хамгаалалтын бүс, сэжигтэй бүсийн айл болон голомтын бүсийн айл өрх, малын тоон судалгааг гаргаж шаардагдах вакцины хүсэлтийг аймгийн мал эмнэлгийн газарт уламжлан шаардлагатай вакциныг татан авчруулсан.

Голомт, сэжигтэй болон хамгаалалтын бүс нутгийн 7 өрхийн хонь-6240, ямаа-2856, үхэр-540, бүгд-9636 толгой малыг вакцинжуулалтад хамруулсан байна. Тарилганд 10,176 л вакциныг зарцуулсан байна.

Одоогоор сумын хэмжээнд хорио цээр тогтоосонтой холбогдуулан малын шилжилт хөдөлгөөн, мах, түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэлтийг зогсоогоод байна.

Орон нутгийн тарилга болох сахуу, Дотрын халдварт хордлого, листериоз зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг татан авч хувийн хэвшлийн мал эмнэлгүүдэд хуваарилан өгч, заавар, зөвлөгөө өгч, тарилгад гарах бэлтгэл хангуулж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж:Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д бүртгэлтэй ажил хайгч 2021 оны 06-р сард шинэ ажлын байранд 3 иргэний мэдээллийг зуучилсан.

2017-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрт хамрагдсан 8 иргэнтэй холбогдож 2407,000 төгрөгийг 100120037010 дансанд төвлөрүүлсэн.

ХЭДС-аас жил бүр зарлагдах санхүүгийн дэмжлэг олгох линкийг сумын группт байршуулж хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгийг сонирхож буй иргэдийг бүртгэж ажилласан. Үүнд. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих" хөтөлбөрт-2 иргэн, "35 ба түүнээс дээш насны иргэний ажлын байрыг дэмжих" хөтөлбөрт-6 иргэн, "Ахмад настны зөвлөх үйлчилгээний хөтөлбөр"-т 1 иргэн, "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т 1 нийт 10 иргэн бүртгүүлснээс 5 иргэний төсөл дэмжигдэж 19 сая төгрөгийн санхүүжилт олгох гэрээ, баримт бичгийг бүрдүүлж хүргүүлсэн.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд аймгийн ХХҮГазарт Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, дэмжигдэж хүнсний талонд хамрагдаж буй 7 айл өрхөөс 5 иргэнийг хамруулж 10 хоногийн хугацаатай уг ажлыг зохион байгуулж ажилласан.

Нийгмийн халамжийн чиглэлээр: 2021 оны 06-р сарын 01-ны өдөр 1-р одон 2 иргэн, 2-р одон 12 иргэн шагнагдаж е-халамж системд бүртгэн 1400,000 төгрөгний тэтгэмжид хамруулсан. Наадмын насны хишигт хамрагдах шинээр 65 нас хүрсэн 11 ахмадын мэдээллийг нэмж бүртгэлээ.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 26 өрхийн 118 иргэн хамрагдаж байгаа ба 06-р сарын 1,464,000 төгрөгийн "Хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бүртгэл"-ийг гэрээт дэлгүүрт бэлтгэн өгч өрхүүдэд олгуулж байна.

2021 оны 06-р сард сумын амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжид 5 иргэнд сунгалт тогтоон шийдвэрлэсэн. мөн хагас жилээр ирц, тайлан гаргаж 7 гишүүнд 604800 төгрөгийн урамшууллыг олгуулсан.

ОНОТХҮ-ний бүлгийн төслийн сонгон шалгаруулалтыг сумын амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн 4 бүлгийн төслөөс 2 өрхийн төслийг сонгон шалгаруулан 1 бүлэг шалгарч Н.Оюунтунгалаг ахлагчтай "Монгол дээл урлал" бүлэгт 1500,000 төгрөгийн санхүүжилт олгогдсон.

Нийгмийн даатгал: ЭМД-д 15 хүний 1177700 төгрөг, сайн дурын даатгалд 23 хүний 985650 төгрөг төвлөрүүлэв. НДШ-д 8-н байгууллагын 52518.8 төгрөгийн орлого орж байна. Одооны байдлаар НДШ бүрэн ороогүй байна. 06 дугаар сарын тэтгэвэрт 2 банкаар 412 хүнд 143042.0 сая төгрөгний тэтгэвэр олгосон. Оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0, жирэмсэн амаржсаны тэтгэмжид 1 хүний 693385 төгрөг олгосон. COVID-19 буюу цар тахалтай холбоотойгоор ЗГ-аас ААНэгжүүдийг НДШимтгэлээс чөлөөлнө гэсний дагуу 16 ААНэгжийг чөлөөлөлтөнд хамрагдуулсан.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторын нийт үзлэг 423, алсын дуудлага 25, гэрийн дуудлага 9, хэвтэн эмчлүүлэгч 11, Нас баралт 0.

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулж байгаа Covid-ийн вакцинжуулалтыг 1, 2-р тунг 18-с дээш насны нийт 2170 иргэн хамрагдахаас 1-р тунг 1957 хүнд, 90,1%-тай, 2-р тунг 1771 хүн, 81,6%-тай хамрагдаад байна.

6 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Covid-ийн вакцинжуулалтыг 12 – 17 насны хүүхдийн 1-р тунг хийгээд байна.

Үүнд: - 12 настай 29 хүүхэд

- 13 настай 36 хүүхэд
- 14 настай 28 хүүхэд
- 15 настай 27 хүүхэд
- 16 настай 35 хүүхэд
- 17 настай 47 хүүхэд нийт 2020 хүүхэд дархлаажуулаад байна.

Эрүүл мэндийн төв нь 2 их эмчийн ажлын орон тоо зарлаад байна. Мөн больницийн барилгын 1 давхрын таазыг шинэчлэх засварын ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 50%-д хүрээд байна.

Тайлан нэгтгэсэн:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг